

GOBI

MONGOLIAN CASHMERE

2022-2023 ОНЫ ШҮГЭЛ ҮЛЭЭХ СИСТЕМИЙН ТАЙЛАН

2024 оны 03 сар



АГУУЛГА

1. Ёс Зүйн кодын холбогдох журмууд
2. Ёс зүйн хорооны гишүүдийн оролцоо
3. Шүгэл үлээх систем
4. Сургалт идэвхжүүлэлт
5. Постер мэдээ
6. Гарын авлага
7. Ёс зүйн хорооны сонгууль
8. Шүгэл үлээх систем сайжруулалт



1. ШИНЭЧИЛСЭН БОЛОН ШИНЭЭР БАТЛУУЛСАН ЖУРМУУД



ТУЗ-ийн тогтоолоор 2023 оны 08 сарын 16-нд
Шүгэл үлээх тогтолцооны үйл ажиллагааны
журмыг **ШИНЭЧЛЭН** батлуулав.



2023 оны 08 сарын 17-ны Гүйцэтгэх захирлын
тушаалаар Ёс зүйн кодын хэрэгжилтийг
зохицуулах журмыг **ШИНЭЭР** батлуулав.



2. ЁС ЗҮЙН ХОРООНЫ ГИШҮҮДИЙН ОРОЛЦОО

“Комплаенс ба эрсдэлийн удирдлага” сургалт /2023.06.14/

Бизнесийн үйл ажиллагаа явуулахад тулгамддаг эрсдэл, комплаенстай холбоотой зөрчлийг тодорхойлох, тухайн нөхцөл үүсэх үед баримтлах комплаенсын стандартыг хэвшүүлэх, олон улсын сайн жишгийг нэвтрүүлэх, практикт суурилсан мэдлэг, чадвар олгоход чиглэгдсэн сургалтанд Ёс зүйн хорооны гишүүд болох Б.Оюун-Эрдэнэ, Г.Отгонжаргал, Б.Энхжин нар хамрагдав.



МҮХАҮТ-ийн Бизнесийн ёс зүйн төвөөс зохион байгуулсан “Комплаенс ба эрсдэлийн удирдлага” сэдэвт сургалтанд Комплаенсын менежер Б.Оюун-Эрдэнэ, ЁЗХ-ны гишүүд болох Г.Отгонжаргал, Б.Энхжин оролцов.

МҮХАҮТ-ийн Бизнесийн ёс зүй, комплаенсын үндэсний II форумд ЁЗХ-ны гишүүд О.Нансалмаа, Б.Оюун-Эрдэнэ, Б.Түмэнбаяр, Д.Нямжаргал нар оролцов.



2023.06.13



2023.04.26



2. ЁС ЗҮЙН ХОРООНЫ ГИШҮҮДИЙН ОРОЛЦОО

Хариуцлагатай бизнес ба хүний эрхийн магадлан шинжилгээний сургалт



2023.09.15

Японы Засгийн газрын дэмжлэгтэйгээр НҮБ-ээс зохион байгуулсан Хариуцлагатай бизнес ба хүний эрхийн магадлан шинжилгээний сургалтад Нийцлийн менежер, ТХ-ийн менежерүүд хамрагдав.



Хариуцлагатай бизнес, шударга байдлын аргачлал хэвшүүлэх сургалт



2023.08.25-26

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Бизнесийн ёс зүйн төвөөс сургагч багш бэлтгэх “Хариуцлагатай бизнес, шударга байдлын аргачлал хэвшүүлэх” сэдэвт сургалтад Ёс зүйн хорооны гишүүд Б.Оюун-Эрдэнэ, Б.Түмэнбаяр, ТУЗ-н мэргэжилтэн Г.Дэмчигсэлмаа нар хамрагдав.

Бенчмарк хөтөлбөрийн танилцуулга



Нийцлийн менежер Б.Оюун-Эрдэнэ оролцов.

2023.07.28

Ёс зүйтэй бизнес - тогтвортой өсөлт сэдэвт хэлэлцүүлэг

Рио Тинто Монгол ХХК-ийн дэмжлэгээр МҮХАҮТ-ийн Бизнесийн ёс зүйн төв болон Эрдэс Баялаг эмэгтэйчүүдийн холбоо ТББ-тай хамтран "Ёс зүйтэй, Тогтвортой өсөлт" сургалт хэлэлцүүлэгт ТУЗ-н мэргэжилтэн Г.Дэмчигсэлмаа, Нийцлийн менежер Б.Оюун-Эрдэнэ нар оролцов.

2023.08.22

3. ШҮГЭЛ ҮЛЭЭХ СИСТЕМ

2022/11/17 – 2023/12/01

Систем болон бусад эх сурвалжаар ирсэн

ЗӨРЧИЛ МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ

Мэдээллийн эх сурвалж	Ирсэн зөрчлийн тоо	Гүйцэтгэл %
Системээр ирүүлсэн	57	93%
Утсаар ирүүлсэн мэдээлэл	9	100%
Өргөдлөөр ирүүлсэн мэдээлэл	8	100%
Нийт	74	97.6%



3. ШҮГЭЛ ҮЛЭЭХ СИСТЕМ


2022/11/17 – 2023/12/01

ЗӨРЧЛИЙН ТӨРӨЛ

Говь ХК нь Комплаенсын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх ажлын хүрээнд Ёс зүйн кодын хэрэгжилтийг хангуулахаар “Шүгэл үлээх систем” ажиллаж байна.

№	Зөрчлийн төрөл	Ирсэн шүглийн тоо	Хувиар
1	Харилцааны зөрчил	13	23%
2	Нийтийн эрх ашгийг хохироосон зөрчил	11	19%
3	Хувь хүний эрхэд халдсан зөрчил	11	19%
4	Ажлын байрны дарамт, шахалттай холбоотой зөрчил	10	18%
5	Эрх мэдлээ урвуулан ашиглахтай холбоотой зөрчил	5	9%
6	Ялгаварлан гадуурхалтай холбоотой зөрчил	3	5%
7	Мөнгө, бараа материал, бусад хөрөнгийн зүй бус ашиглалттай холбоотой зөрчил	2	4%
8	Андуурч ирсэн мэдээлэл	1	2%
9	Залилан мэхлэхтэй холбоотой зөрчил	1	2%


Зөрчлийн төрөл %



3. ШҮГЭЛ ҮЛЭЭХ СИСТЕМ


2022/11/17 – 2023/12/01

ЗӨРЧИЛ, ҮЛ ТОХИРЛЫН ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДЛААР



3. ШҮГЭЛ ҮЛЭЭХ СИСТЕМ


ЁС ЗҮЙН ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА



Зөвлөмж	18
Шийдвэр	6
Мэдэгдэл	2

Ёс зүйн хороо нь 2022/12/08 – 2023/12/01 хугацаанд нийт 26 хурал зарлан хуралдаж шүгэл үлээх систем болон бусад эх сурвалжаар ирсэн мэдээллүүдтэй танилцах, тодруулга авах, нягтлан шалгах гэсэн үе шатуудтайгаар шийдвэр болон зөвлөмж, мэдэгдэл гарган ажиллав.

ШИЙДВЭР, ЗӨВЛӨМЖ



4. СУРГАЛТ ИДЭВХЖҮҮЛЭЛТ



Сургалтаар **Ёс зүйн код** болон **Шүгэл үлээх систем**-ийн ач холбогдол, **Ёс зүйн хороо**-ны үүрэг, үйл ажиллагааны талаарх мэдлэг ойлголт өгөв.



Нийт ажилтнуудад “**Ёс зүйн код**” болон холбогдох журмуудыг таниулах, нэгдсэн ойлголт өгөх зорилготой **849 хүн цаг сургалт** оров.



5. ПОСТЕР МЭДЭЭ

GOBI MONGOLIAN CASHMERE

GLOBAL ETHICS DAY 2023

ӨНӨӨДӨР БУЮУ 2023.10.18-НЫ ӨДӨР “ДЭЛХИЙН ӨС ЗҮЙН” ӨДӨР ТОХИОЖ БАЙНА.

Говь ХК-ийн хамт олон компанийн үнэт зүйлд суурилсан өс зүйн кодыг өдөр тутмын ажил үйлсдээ мөрдлөг болгон ажиллаж байна. Өс зүйн код дараах үндсэн зарчмуудыг агуулж байдаг.

Үүнд:

- 1 Бид аюулгүй ажиллагааг нэгдүгээрт тавина;
- 2 Бид олон талт ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, нээлттэй, харилцан хүндэтгэлтэй санаа бодлоо солилцоно;
- 3 Бид шударга бус явдлын хажуугаар чимээгүй өнгөрөхгүй байхыг чухалчилж, зөв хүн байна;
- 4 Бид ажлын байранд аль ч төрлийн дарамт, хавчлагыг үл тэвчинэ;
- 5 Бид мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллана;
- 6 Бид оюуны өмчийг дээдэлнэ;
- 7 Бид хувийн нууцыг чандлан хамгаална.

Өдөр тутмын ажил үйлсдээ “Өс зүйн код”-ыг мөрдлөг болгон ажилладаг нийт ажилтнууд, хамтран зүтгэгчдэдээ “Дэлхийн Өс Зүйн Өдөр”-ийн мэнд хүргэе.



“Дэлхийн өс зүйн өдөр”-тэй уялдуулан Байгууллагын Өс зүйн кодын ач холбогдлыг **ГАДААД ДОТООДЫН СУВГААР ЦАЦАВ.**

GOBI ETHICS



АЖЛЫН БАЙР, ТАЛБАЙД ЭЛЕКТРОН ТАМХИ ТАТАХГҮЙ БАЙЦГААЯ

ТАМХИ ХАЯХ АРГА ЗАМ НЬ ЭЛЕКТРОН ТАМХИ БИШ!

Энгийн тамхнаас ялгаатай нь электрон тамхи нь амтлаг, татаж байгаа хүний аманд таагүй амт нэвдэгддэггүй. Гэвч электрон тамхи хэрэглэх байгаа хүн өөрийгөө хангах боломжгүй байдаг аж. Учир нь энгийн тамхи татаж дуусахад тамхи дуусгалаа гэдэг дохио тархинд очдог бол электрон тамхины хувьд зогсох дохио өгөх зүйлгүй учраас татсаар л байдаг сөрөг галтай. Тиймээс хэтрүүлж хэрэглэх магадлалтай. Хэтрүүлсэн үед толгой дүүрэх, чих шуулж, толгой эргэх, хөл жавар бие булчлах сулрах, долоо эгнүүрх зэрэг шинэ тэмдэг илрэдэг. Электрон тамхинд агуулагдаж бодис нь зүрх судас, уушгины өвчлөл, жирэмсэн эхүүдийн хувьд ургийн хөгжилд сөргөөр нөлөөлөх магадлалтай.

- 1 Хэрвээ вайл удаан хугацаанд татсан өрөөнд тамхи татдаггүй хүн орвол шашныг үнэр үнэрэдэг байна. Энэ нь никотины бүрэлдэхүүнд ордог амниак үнэртэй байгаагийн илрэл аж.
- 2 Никотин ой тогтоолт, өөрийгөө ханах, суралцах үйл явц зэрэг тархины үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг.
- 3 ДЭМБ-аас электрон тамхи болон никотин өлгөрүүдэд бусад бүтээгдэхүүний борлуулалтыг хязгаарлахыг зөвлөж байна. Вэйнийг одоогоор 27 улсад хоригложээ.

АЖЛЫН БАЙРАНД ЭЛЕКТРОН ТАМХИ ТАТАХ НЬ ХАМТРАН АЖИЛЛАГСДАД ТААГУЙ МЭДЭЭМЖ ТӨРҮҮЛЖ БОЛЗОШУЙ ТҮЛ БҮСДДАА ХҮНДЭТГЭЛТЭЙ ХАНДАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.

“ГОВЬ ХК”-ИЙН ӨС ЗҮЙН ХОРОО

Оффисын орчин дах электрон тамхины хэрэглээг багасгах, хор уршгийг таниулсан постер мэдээлэл цацав.

GOBI MONGOLIAN CASHMERE

ӨС ЗҮЙН ХОРОО



ӨС ЗҮЙН ЗӨРЧИЛ ХҮЛЭЭН АВАХ СУВГУУД

Цахим хаяг: info.gobi.mn/whistleblowing | Утас: 7013 9977-7, 9995 7465 | E-mail: wb@gobi.mn

Аман байдлаар: Ярилцлагын хуудсаар | Албан бичгээр: Өргөдөл



Дээрх QR кодыг та интернет сүлжээтэй бол хаанаас ч уншуулж шүгэл үлээх системтэй холбогдож болно

Өс зүйн зөрчил хүлээн авах сувгийн боршур мэдээлэл оффисын мэдээллийн самбар дээр байршуулав.


GOBI MONGOLIAN CASHMERE

Хүн бүрийн төрөлөөс заяатдсан суурь эрхийг ижил тэгш байна хэмээн тунхаглан зарласан “Хүний эрхийн өдөр”-ий өгөгдөдөр буюу 12 сарын 10-ны өдөр дэлхий нийтээрээ тэмдэглэж өнгөрүүлж байна.

ГОВЬ ХК нь Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд хүн бүрийн эрх, эрх чөлөөлөг дээдлэн Хүний эрхийн түгээмэл тунхаглал-д нэгдэж, аливаа харилцаанд эрх тэгш, найрсаг, хүндэтгэлтэй байх зарчмыг үйл ажиллагааныхаа бүхий л үе шатанд баримтлан ажилладаг.

ГОВЬ ХК-ийн хэрэглэгч, хувьцаа эзэмшигч, ханган нийтлүүлэгч, нийт ажилтнууд тө бүхэндээ

ХҮНИЙ ЭРХИЙН ОЛОН УЛСЫН ӨДРИЙН МЭНДИЙГ ХҮРГЭЭ.



Хүн бүрийн эрх, эрх байдлыг хүлээн зөвшөөрч, нээлттэй бие биетэй харилцан хүндэтгэлтэй ажиллах санал бодлоо солилцож, бие биэдээ эол тэгш ханддаг бол бүтээгдэхүүнийг уламж байна.

“ГОВЬ ХК” - Өс Зүйн Хороо

“Хүний Эрхийн ОУ-ын Өдөр”-тэй уялдуулан Байгууллагын Үнэт зүйлсийг **ГАДААД ДОТООДЫН СУВГААР ЦАЦАВ.**



6. ГАРЫН АВЛАГА



Ёс зүйн хорооны сонгуулийн үеэр Ёс зүйн гарын авлага ажилтнуудад хэвлэмэл хэлбэрээр хүрч <https://eportal.gobi.mn> дотоод сүлжээнд байршив.

7. ЁС ЗҮЙН ХОРООНЫ СОНГУУЛЬ



GOBI
MONGOLIAN CASHMERE

ЁС ЗҮЙН ХОРОО БАЙГУУЛАХ ТУХАЙ СОНГУУЛИЙН ТОВ:

ГАЗАР, ХЭЛТЭС	ХУГАЦАА	БАЙРШИЛ
+	2023.12.18	+
ГБГ, Гадаад маркетингийн хэлтэс, Компани хөгжүүлэлтийн хэлтэс, Хүний нөөцийн хэлтэс /Борлуулалт/	Ёс зүйн хорооны гишүүн 1	Говь, Глобал оффис
Дотоод борлуулалтын газар, Экспорт борлуулалтын газар	Ёс зүйн хорооны гишүүн 1	Говь, Говь оффис Төв дэлгүүр нэгж, Галперай УБ нэгж
Дизайн хөгжүүлэлтийн газар	Ёс зүйн хорооны гишүүн 1	Говь оффис
ТУХ, УТХ	Ёс зүйн хорооны гишүүн 1	Говь оффис
АШУ, ЭУ, НҮ, ОУ, СУ	Ёс зүйн хорооны гишүүн 5	Говь Үйлдвэр, Говь Үйлдвэр
Санхүүгийн газар + ХАХ	Ёс зүйн хорооны гишүүн 1	Говь оффис
Хүний нөөцийн газар	Ёс зүйн хорооны гишүүн 1	Говь оффис
Мэдээлэл технологийн газар	Ёс зүйн хорооны гишүүн 1	Говь, Говь оффис
ЧСБХ, ХЭМАБ, ХХ, ТУЭ-ийн ажлын алба, ДАХ, ТХХ	Ёс зүйн хорооны гишүүн 1	Говь, Говь оффис

* "GOBI" ХХ - Тогтвортой өсөлтийн хэлтэс *



2023 оны 12 сарын 18-нд жилд 1 удаа зохион байгуулдаг **ЁС ЗҮЙН ХОРООНЫ ГИШҮҮН** сонгох ээлжит сонгуулийг бүх газар, хэлтэс, үйлдвэрийн ажилтнууд дунд зохион байгууллаа. Ёс зүйн хорооны гишүүнээр ёс зүйн манлайлалтай, үлгэр жишээ, итгэл хүлээлгэсэн ажилтнуудыг нээлттэй сонгуулийн зарчмаар явуулж Үйлдвэр, хэлтсийн төлөөллөөр 13 гишүүн сонгогдов.

Ёс зүйн хороо болон Нэр дэвшүүлэх хороо нь компанийн хэмжээнд илэрсэн ёс зүйн зөрчлүүдийг **ХЯНАН ШИЙДВЭРЛЭЖ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВДАГ.**



8. ШҮГЭЛ ҮЛЭЭХ СИСТЕМ ИЙН САЙЖРУУЛАЛТ

Шүгэл үлээх систем нь 2022 оны 11 сард ашиглалтад орсноос хойш системд тасралтгүй сайжруулалт хийсээр байгаа.

- Хэрэглэгч <https://info.gobi.mn/whistleblowing/system-pyy> ороход богино асуулга, тодруулга авдаг байхаар;
- Шүгэл үлээгч мэдээлэл оруулах үед бөглөх асуултуудад заавал сонгодог байхаар өөрчлөлт хийгдэв.

- 1 Би яг одоо сэтгэл зүйн хувьд тайван байна.
- 2 Миний илгээж буй мэдээлэл үнэн зөв бөгөөд бусдын эрхэд халдаагүй гэдэгт би итгэлтэй байна.
- 3 Би нотлох баримттай.
- 4 Би нотлох баримтаа хууль бусаар цуглуулаагүй
- 5 Би Говь ХК-н үйл ажиллагааг засаж сайжруулахын төлөө шүгэл үлээж байгаадаа итгэлтэй байна.

- Хэрвээ таны илгээх гэж буй мэдээлэл зөрчил мөн эсэхийг мэдэхгүй байгаа бол та 70048888-4 дугаарт холбогдох эсвэл wb@gobi.mn и-мэйл хаягт хандан зөвлөгөө авч болно.
- Таны шүгэл үлээх гэж буй мэдээлэл зөрчил мөн эсэхэд эргэлзэж байгаа бол Говь ХК-н Ёс зүйн кодтой танилцаарай. [Ёс зүйн код](#)
- Хэрэв таны мэдээлэл санал, гомдол бол Говь ХК-н Архив санал гомдлын мэргэжилтэнтэй холбогдоно уу. [\(+976\) 9990-5357](tel:+97699905357)

Зөвшөөрч байна

Харагдах байдлыг шинэчлэн хэрэглэгчдэд ойлгомжтой байх үүднээс нэгдсэн мэдээллийг төвлөрүүлэв.

Хэн шүгэл үлээх вэ?

Манай байгууллагын үйл ажиллагаатай холбоотой ёс зүйн зөрчил болон шударга бус үйлдлийн талаар...

Шүгэл Үлээх >

Мэдээллийн явцыг шалгах


Та шүгэл үлээсэн мэдээллийн явцыг эндээс шалгана уу.

Цааш нь >

Шүгэл үлээх системийн зорилго

Оролцогч талуудтай ур ашигтай харилцааг нэмэгдүүлж, байгууллагын үйл ажиллагааны доголдлыг эрт үед нь илрүүлэх, засаж сайжруулах, ажилтан ...

ЯЛГАВРАЛЫН ГАРУУЛАХ





**АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА**

